



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар  
ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудит

Аудитын код: ДАА-2022/05-НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: **Ч.Цэрэннадмид**

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tsebs.audit@gmail.com](mailto:tsebs.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,  
Дархан сум, 14-р баг  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
E-mail: darkhanuul@audit.gov.mn

дснз . 03 . 15 № АМҮ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА  
ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

009020331

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4.1 Залруулсан алдаа.....	
4.2 Албан шаардлага, зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

### Товчилсонүгийнжагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	01 сарын 01	12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	130,634,328.62	230,394,084.24
1.1.2	Дансны авлага	4,308,516.63	2,613,499.63
1.1.6	Бараа материал	4,209,849.61	5,182,113.26
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>139,152,694.86</b>	<b>238,189,697.13</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	42,413,235.46	30,678,977.11
1.2.2	Биет бус хөрөнгө	1,680,000.00	1,020,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>44,093,235.46</b>	<b>31,698,977.11</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>183,245,930.32</b>	<b>269,888,674.24</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		1,392,400.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	12,978,968.29	27,360,271.91
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	8,026,372.00	19,951,682.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>21,005,340.29</b>	<b>48,704,353.91</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>21,005,340.29</b>	<b>48,704,353.91</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн	18,193,545.00	18,193,545.00
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,458,827.00	21,458,827.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	122,588,218.03	181,531,948.33
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>162,240,590.03</b>	<b>221,184,320.33</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>183,245,930.32</b>	<b>269,888,674.24</b>




## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>288,126,157.73</b>	<b>372,050,636.10</b>
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>288,126,157.73</b>	<b>372,050,636.10</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	565,054.56	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		1,614,363.63
9	Борлуулалт, маркетингийн зардал		-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	237,587,865.06	285,446,679.24
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(13,221,111.11)	(736,125.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>37,882,236.12</b>	<b>87,482,195.49</b>
19	Орлогын татварын зардал	5,162,749.26	8,586,783.19
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>32,719,486.86</b>	<b>78,895,412.30</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>32,719,486.86</b>	<b>78,895,412.30</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		-
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		




### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>317,504,251.50</b>	<b>410,702,285.41</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	317,263,532.50	409,999,672.41
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	240,719.00	632,613.00
	Бусад мөнгөн орлого		70,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>270,453,398.21</b>	<b>302,571,257.79</b>
	Ажиллагчдад төлсөн	111,165,687.51	102,065,403.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	31,721,087.75	30,431,118.17
	Бараа материал худалдан авахад төлсөн	3,875,660.00	5,126,633.00
	Ашиглалтын зардалд төлсөн	11,677,865.00	10,458,440.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,444,450.00	12,624,900.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	48,924,908.12	27,628,857.62
	Даатгалын төлбөрт төлсөн	264,010.00	234,010.00
	Бусад мөнгөн зарлага	52,379,729.83	114,001,896.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>47,050,853.29</b>	<b>108,131,027.62</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	565,054.56	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	565,054.56	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,600,000.00	344,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,600,000.00	344,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(8,034,945.44)</b>	<b>(344,900.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,781,382.00	8,026,372.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг	17,781,382.00	8,026,372.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(17,781,382.00)</b>	<b>(8,026,372.00)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>21,234,525.85</b>	<b>99,759,755.62</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>109,399,802.77</b>	<b>130,634,328.62</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>130,634,328.62</b>	<b>230,394,084.24</b>



**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Эмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.... оны ..-р сарын ..-ний үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	97,895,103.17	137,547,475.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	18,193,545.00	21,458,827.00	97,895,103.17	137,547,475.17
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			32,719,486.86	32,719,486.86
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг			(8,026,372.00)	(8,026,372.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	20.... оны .. -р сарын .. -ний үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	122,588,218.03	162,240,590.03
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	18,193,545.00	21,458,827.00	122,588,218.03	162,240,590.03
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			78,895,412.30	78,895,412.30
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг			(19,951,682.00)	(19,951,682.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	20.... оны .. -р сары ..-ний үлдэгдэл	18,193,545.00	21,458,827.00	181,531,948.33	221,184,320.33



Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	м/төг	<b>288,691.1</b>	<b>370,000.0</b>	<b>373,665.0</b>	<b>3,665.0</b>	<b>100.9</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	288,691.1	370,000.0	373,665.0		
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	м/төг	<b>288,691.1</b>	<b>370,000.0</b>	<b>373,665.0</b>	<b>3,665.0</b>	<b>100.9</b>
	Үүнээс:	м/төг					
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг						
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	237,587.8	336,931.2	285,446.7	(51,484.5)	
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	м/төг	13,221.1		736.1	736.1	
<b>4</b>	<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	м/төг	<b>37,882.2</b>	<b>33,068.8</b>	<b>87,482.2</b>	<b>54,413.4</b>	



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын /цаашид Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн авлагын данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Т.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал

дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн орлогын тайлангийн нийт зардлын 237,587.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,375.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,900.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын “Барилга байгууламж барих, засварлах, шинэчлэх, өргөтгөх ажлыг гүйцэтгэх нөхцөлийг зохих ёсоор бүрдүүлж эхлүүлэх, гүйцэтгэх явцад батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах, материал, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг оновчтой зохион байгуулах, барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулахтай холбоотой барилга захиалагчийн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилгын техникийн хяналтыг гүйцэтгэх ажлын хүрээнд зураг төсөв болон бусад холбогдох дүрэм журмыг баримтлан угсралтын ажилд ашиглаж байгаа материалын чанар байдал орц нормыг техникийн тодорхойлолтод заасны дагуу хянаж барилга угсралтын ажлын явцад гарсан зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулж, тулгамдсан асуудлыг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэж гүйцэтгэгчид зөвлөмж болон үүрэг даалгавар өгч ажилладаг байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэж бүртгэгдсэн байна. Үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

#### **4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	130,634.3	230,394.1	99,759.8
Авлага	4,308.5	2,613.5	(1,695.0)
Бараа материал	4,209.8	5,182.1	972.3
Үндсэн хөрөнгө	42,413.2	30,678.9	(11,734.3)
Биет бус хөрөнгө	1,680.0	1,020.0	(660.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>183,245.9</b>	<b>269,888.6</b>	<b>86,642.7</b>
Өр төлбөр	21,005.3	48,704.3	27,699.0
Эздийн өмч	18,193.5	18,193.5	-
Эздийн өмчийн бусад хэсэг	21,458.8	21,458.8	-
Хуримтлагдсан ашиг	(122,588.2)	(181,531.9)	58,943.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>183,245.9</b>	<b>269,888.6</b>	<b>86,642.7</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 99,759.8 мянган төгрөгөөр өсөхөд 410,702.3 мянган төгрөгийн орлого орж, 310,942.5 мянган төгрөгийн зардал гарсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 1,695.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг тайлант онд барагдуулсанаас голлон шалтгаалсан байна. Нийт авлагын үлдэгдэлд төсвийн байгууллагуудаас авах хяналтын зардлын үлдэгдэл 2,613.5 мянган төгрөг нь аж ахуй нэгжээс авах авлага 100 хувийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 972.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 19,056.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 18,084.1 мянган төгрөгийн материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,818.8 мянган төгрөгөөр буурсан нь 344.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч, 2021.05.31-ний өдрийн №01-А/163 тоот засаг даргын захирамжаар 3,186.7 мянган төгрөгийн компьютер, 976.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил /сандал, зурагт/ 3 нэр төрлийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 27,699.0 мянган төгрөгөөр өссөн нь ААНОАТ-ын өглөг 3,485.6 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 7,704.4 мянган төгрөг, НӨАТ-ын өглөг 3,163.0 мянган төгрөг, ногдол ашгийн өглөг 11,925.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ХХОАТ-ын өглөг 7,704.3 мянган төгрөг нь татварын байгууллагын системд нэхэмжлэх үүсээгүйгээс төлөх боложгүйгээс өр төлбөр үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 18,458.8 мянган төгрөг байна. Өөрчлөлт ороогүй.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 181,531.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 58,943.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

#### **4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дархан хот байгуулалт, барилга захиалгчийн газар” ОНӨААТҮГ-ын байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус байгууллагын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг орон нутгийн өмчийн газар, АЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэс хянаж, Засаг дарга баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 370,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 336,931.2 мянган төгрөгөөр, 33,068.8 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 373,665.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 286,182.8 мянган төгрөгийн зардал гарган, 87,482.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 373,665.0 мянган төгрөг болж төлөвлөснөөс 3,665.0 мянган төгрөг буюу 0,9 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 336,931.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 286,182.8 мянган төгрөг буюу 17.7 хувиар хэмнэлттэй ажилласан байна. Энэ нь улсын их хурлаас гаргасан 43-р тогтоолоор хэмнэлт гаргасан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 87,482.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 54,413.4 мянган төгрөгөөр илүү байгаа нь сайдын эрх шилжсэн ажилд хяналт тавьсан нь нөлөөлж байна.

Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит газрын дүрмийн 5 дахь бүлгийн 5.9 дэх “Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас 25 хүртэл хувийг ногдол ашиг хэлбэрээр аймгийг төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтын дагуу тайлант онд 19,951.7 мянган төгрөгийн ногдол ашгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 410,700.0 мянган төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 146 мэдээллийг ил тод байршуулсан байна.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,018.2 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,018.2					
Нийт дүн	2	1,018.2					

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 152,490.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 132,862.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 19,627.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 8.1 Залруулсан алдаа

- Мөнгөн гүйлгээний тайлангийн эцсийн үлдэгдэл 132,862.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

### 8.2 Зөвлөмж

**Илрүүлэлт:** НӨАТ-ын өглөг 10,988.3 мянга, ААНОАТ-ын өглөг 8,639.2 мянга нийт 19,627.5 мянган төгрөг байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, НӨАТ-ын тухай хуулийн 16 дугаар

зүйлийн 16.1-д “Албан татвар суутган төлөгч нь борлуулсан бараа, ажил үйлчилгээнд ногдох албан татварыг доор дурдсан журмаар дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулж барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан хот байгуулалт, барилга захиалагч ОНӨААТҮГ-ын	2	152,490.3	1	132,862.8					1	19,627.5